

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант ус дулаан түгээх станц ОНӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2026/001/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2026он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: Ц.Одгэрэл
Утас: 70357955 Цахим хаяг: odgerelts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.03.05 № 25
танай _____-ны № _____-т

“ЖАРГАЛАНТ УС ДУЛААН ТҮГЭЭХ
СТАНЦ” ОНӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ П.ЭНЭМОНОО ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант ус дулаан түгээх станц ОНӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Жаргалант ус дулаан түгээх станц ОНӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Орон нутагт ажилласны нэмэгдэл цалинд 109,682.6 мянган төгрөг олгосон,
2. Санхүүгийн тайланд тусгагдсан 6,176.3 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй,
3. Аймгийн Санхүү, хяналт, дотоод аудитын албаны хяналт шалгалтаар тавигдсан 687.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг буруутай этгээдээр төлүүлэлгүй, байгууллагын хөрөнгөөс барагдуулсан,
4. Байгууллагын хөрөнгөөр 1,018.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан,
5. Шатахууны урамшуулал 798.0 мянган төгрөгийг бүртгэл тайланд тусгалгүй хувийн хэрэглээнд зарцуулсан байна.

☎ 612505475

Дээрх зөрчлүүд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3.1-д "Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна:", 3.1.3-д "банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна:", 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтуудтай нийцэхгүй, бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь аудитын иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын 2025 оны А/601 дүгээр захирамжаар дулаан, хэрэглээний халуун хүйтэн усаар хангагддаг орон сууцны барилга, аж ахуй нэгжийн барилгын талбайн болон эзлэхүүний хэмжээг баталгаажуулах, хэрэглээний халуун хүйтэн усны болон дулааны тоолуурын ажиллагааны баталгаажуулалт хийх ажлыг зохион байгуулсан нь дараа онд тус компанийн борлуулалтын орлогыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлэхээр байна.

Аудитын гол асуудал

Тус компани нь Орхон аймгийн төсвөөс Жаргалант сумын гэр хорооллын иргэдийг цэвэр усаар тасралтгүй, найдвартай хангах зорилгоор ус түгээх байруудын урсгал зардалд 50,000 мянган төгрөг, Жаргалант сумын төсвөөс дулааны станцын алдагдалд 411,927.9 мянган төгрөг, нийт орон нутгийн төсвөөс 461,927.9 мянган төгрөгийн татаас авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус компанийн гүйцэтгэх захирал 2 удаа, нягтлан бодогч 3 удаа өөрчлөгдсөн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох

бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	115,689,635.80	74,857,722.61
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,876,797.95	671,686.40
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,876,797.95	671,686.40
31213	Арилжааны банк дахь харилцах	1,876,797.95	671,686.40
33	АВЛАГА	68,737,337.85	8,673,234.15
33401	Дансны авлага /ТӨҮГ/	26,509,859.00	8,673,234.15
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	42,227,478.85	-
35	БАРАА МАТЕРИАЛ	45,075,500.00	65,512,802.06
35100	Түүхий эд материал	39,153,500.00	58,372,802.06
35110	Тусгай зориулалттай материал	39,153,500.00	58,372,802.06
35400	Хангамжийн материал	5,922,000.00	7,140,000.00
35470	Бусад хангамжийн материал	5,922,000.00	7,140,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,275,187,042.51	3,964,391,932.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,275,187,042.51	3,964,391,932.89
39100	Газар	-	4,497,000.00
39200	Биет хөрөнгө	4,271,167,299.59	3,953,930,341.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,637,444,763.76	3,781,346,816.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	(458,048,853.49)	(712,605,086.08)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	871,991,250.82	892,760,542.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	(263,024,161.69)	(378,855,683.88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,801,000.00	11,773,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,979,187.32)	(3,593,474.96)
39209	Зам, гүүрийн байгууламж	248,330,962.00	433,262,507.72
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	(85,973,389.99)
39214	Бусад үндсэн хөрөнгө	329,741,587.55	18,903,618.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(120,090,062.04)	(3,088,508.65)
39300	Биет бус хөрөнгө	4,019,742.92	5,964,591.32
39301	Програм хангамж	6,045,455.00	10,005,455.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,025,712.08)	(4,040,863.68)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	4,390,876,678.31	4,039,249,655.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	153,629,746.12	173,659,835.31
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	153,629,746.12	173,659,835.31
41300	Өглөг	74,376,802.54	143,337,085.78
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	9,267,788.32	1,148,628.84
41360	Бусад өглөг	65,109,014.22	142,188,456.94
41361	Байгууллагад төлөх өглөг	27,367,200.00	975,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,281,300.00	-
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	35,182,046.56	100,301,070.92
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	278,467.66	40,912,386.02
41400	Урьдчилж орсон орлого	79,252,943.58	30,322,749.53
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	79,252,943.58	30,322,749.53
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,237,246,932.19	3,865,589,820.19
51	Засгийн газрын хувь оролцоо	4,237,246,932.19	3,865,589,820.19
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	4,809,936,439.20	4,809,936,439.20
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	-	4,497,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	(572,689,507.01)	(948,843,619.01)
51210	Өмнөх үеийн үр дүн	(497,718,839.74)	(572,689,507.01)
51220	Тайлант үеийн үр дүн	(74,970,667.27)	(376,154,112.00)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	4,390,876,678.31	4,039,249,655.50

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,059,540,209.21	(375,451,625.06)
11	ТАТВАРЫН ОРЛОГО	236,999,325.60	-
110	Орлогын албан татвар	236,999,325.60	-
1100	Хувь хүний орлогын албан татвар	236,999,325.60	-
110003	Хөрөнгийн орлого	236,999,325.60	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	822,540,883.61	(375,451,625.06)
120	Нийтлэг татварын бус орлого	822,540,883.61	(375,451,625.06)
1201	Хүүгийн орлого	48,030.75	-
120002	Бусад хүүгийн орлого	48,030.75	-
120009	Бусад орлого	524,079,300.00	35,552,495.48
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	799,240,445.04	1,233,047,814.22
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	500,826,892.18	1,644,051,934.76
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,134,510,876.48	702,486.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,134,510,876.48	702,486.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,134,510,876.48	702,486.94
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,134,510,876.48	702,486.94
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	1,108,332,464.35	-
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	20,515,807.88	-
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	17,821.78	-
210813	Бусад зардал /ТӨҮГ/	5,624,980.50	687,000.00
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	19,801.97	15,486.94
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(74,970,667.27)	(376,154,112.00)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(74,970,667.27)	(376,154,112.00)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,809,936,439.20	(497,718,839.74)	4,312,217,599.46
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,809,936,439.20	(497,718,839.74)	4,312,217,599.46
9	Тайлант үеийн үр дүн	-	(74,970,667.27)	(74,970,667.27)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,809,936,439.20	(572,689,507.01)	4,237,246,932.19
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,809,936,439.20	(572,689,507.01)	4,237,246,932.19
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,497,000.00	-	4,497,000.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,814,433,439.20	(572,689,507.01)	4,241,743,932.19
19	Тайлант үеийн үр дүн	-	(376,154,112.00)	(376,154,112.00)
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,814,433,439.20	(948,843,619.01)	3,865,589,820.19

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,323,517,765.01	1,245,677,092.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,323,517,765.01	1,245,677,092.41
120	Нийтлэг татварын бус орлого	1,323,517,765.01	1,245,677,092.41
120009	Бусад орлого	198,019.97	1,378,694.36
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	799,240,445.04	782,370,438.05
120017	Татаас, санхүүжилтийн орлого /ТӨҮГ/	524,079,300.00	461,927,960.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,322,985,337.56	1,226,352,293.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,322,985,337.56	1,226,352,293.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,322,985,337.56	1,226,352,293.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	359,442,652.00	424,625,556.01
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	359,442,652.00	424,625,556.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,372,754.24	83,579,427.24
210201	Тэтгэврийн даатгалын зардал	-	54,744,524.84
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	-	5,766,980.48
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	-	8,023,625.01
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	-	1,922,326.83
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	-	13,121,970.08
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	112,372,754.24	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,258,946.84	82,450,695.93
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	55,258,946.84	82,450,695.93
2104	Хангамж, бараа материалын зардал	103,245,360.51	586,589,614.01
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	29,162,318.51	30,989,000.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	74,083,042.00	555,600,614.01
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	692,665,623.97	49,107,000.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,061,250.44	-
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	61,413,366.46	28,576,668.07
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	630,191,007.07	20,530,332.71
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	532,427.45	19,324,798.44
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	178,217.70	-
140007	Хүлээн авсан хүүний орлого	178,217.70	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	13,331,636.37	20,529,909.99
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,331,636.37	20,529,909.99
2200	Дотоод эх үүсвэрээр	13,331,636.37	20,529,909.99
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	13,331,636.37	20,529,909.99
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(13,153,418.67)	(20,529,909.99)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(12,620,991.22)	(1,205,111.55)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,497,789.17	1,876,797.95
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,876,797.95	671,686.40

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 118,649.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 2,791.0 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 115,858.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, үйл ажиллагааг сайжруулах 2 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн, шатахууны урамшууллыг хувийн хэрэглээнд зарцуулсан, дотоод аудитын хяналт шалгалтаар тавигдсан актыг буруутай этгээдээр төлүүлээгүй зэрэг нийт 2,791.0 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Орон нутгийн нэмэгдэл цалинд 109,682.6 мянган төгрөг зарцуулсан, санхүүгийн тайланд тусгагдсан 6,176.3 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчилд 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант оны хөрөнгийн эцсийн үлдэгдлийг эд хариуцагчийн карттай тулгаж тоолоогүй, тооллогыг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4.1-д "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", 72.4.4-д "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн тооллого хийхдээ эд хариуцагчийн карттай тулгаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жаргалант ус дулаан түгээх станц ОНӨХК												
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жаргалант ус дулаан түгээх станц ОНӨХК	7	118,649.9	4	2,791.0	2	115,858.9	1	-				
Дүн	7	118,649.9	4	2,791.0	2	115,858.9	1	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Жаргалант ус дулаан түгээх станц ОНӨХК	1	-							1	-
Дүн	1	-							1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Жаргалант ус дулаан түгээх станц ОНӨХК										
Дүн										
Нийт дүн	1	-							1	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		